2.4 БЭЛТГЭЛ АНГИ

MŠ, ZŠ

Бэлтгэл анги нь цэцэрлэг, бага сургуулийн нэгдүгээр ангийн хоорондох анги юм. Бэлтгэл ангиуд нь бага сургуулиудаас байгуулагдсан бөгөөд **заавал сургуульд хамрагдах хугацааг хойшлуулсан** хүүхдүүдэд зориулагдсан (сургуулийн захирлын зөвлөмжийн дагуу эцэг эхийн хүсэлтээр эсвэл сургуулийн **зөвлөгөө өгөх байгууллагын (ŠPZ)** зөвлөмжийн дагуу хойшлуулагдсан хүүхэд байж болно).

Бэлтгэл ангийн зорилго нь хүүхдийг нэгдүгээр ангийн боловсролын хөтөлбөрт бэлдэх, системтэй хөгжүүлэх юм.

БЭЛТГЭЛ АНГИД ЭЛСЭЛТЭЭР ОРХОД ШААРДЛАГАТАЙ:

- ☑ бага сургуульд элсүүлэх тухай бичгээр гаргасан өргөдөл
- ☑ хүүхдийн төрсний гэрчилгээ, эцэг эхийн бичиг баримт
- ☑ сургуулийн зөвлөх байгууллагын зөвлөмж (эсвэл хүүхэд элсэж байсан бага сургуулийн захирлын зөвшөөрөл)

ХААНА БҮРТГҮҮЛЭХ ВЭ:
бага сургуулийн захиралд

БЭЛТГЭЛ АНГИД ХҮҮХЭД ОРУУЛАХ ХҮСЭЛТИЙГ ХЭН ГАРГАЖ БОЛОХ ВЭ:
хүүхдийн хууль ёсны төлөөлөгч

БЭЛТГЭЛ АНГИ ХААНА БАЙНА:
Та нутаг дэвсгэрийнхээ аль бага сургуулиуд бэлтгэл анги явуулж байгаа талаар мэдээлэл цэцэрлэг ба сургуулийн зөвлөгөө өгөх газар эсвэл холбогдох боловсролын хэлтэс дээр авах боломжтой.

Хүүхдийг бэлтгэл ангид оруулах асуудлыг бага сургуулийн захирал шийддэг.

Хэрэгтэй холбоосууд:

https://inkluzivniskola.cz/pripravne-tridy-na-zs/

Сургууль орох хугацааг хойш луулах

Сургуулийн зөвлөх байгууллагууд (ŠPZ)